2025 оны 4 дүгээр улирлын байдлаар зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 92.0 хувь буюу 267,467,453.11 мянган төгрөгийг хэвийн зээл, 5.1 хувь буюу 14,719,055.60 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.0 хувь буюу 8,690,006.40 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 23,409,062.00 мянган төгрөгийн үлдэгдэлд 28.2 хувь буюу 6,595,406.30 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна. Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 91.5 хувийг хэвийн, 3.4 хувийг хугацаа хэтэрсэн, 5.1 хувийг чанаргүй зээлдэгч эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,441 зээлдэгчийн 8,690,006.40

мянган төгрөгийн үлдэгдлийн 26.7 хувийг хэвийн бус, 32.4 хувийг эргэлзээтэй, 40.9 хувийг муу зээлийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 пунктээр буурч 92.0 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 2.2 пунктээр өсөж 5.1 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.6 пунктээр өсөж 3.0 хувь болсон үзүүлэлттэй байна.

График 7: Зээлийн чанар



Хүснэгт 15: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар (мянган төгрөгөөр)


Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
<b>Нийт</b>	<b>212,003,181.20</b>	<b>100.0%</b>	<b>72.9%</b>	<b>78,873,333.90</b>	<b>100.0%</b>	<b>27.1%</b>
Хэвийн	193,538,419.67	91.3%	72.4%	73,929,033.44	93.7%	27.6%
Хугацаа хэтэрсэн	11,825,399.33	5.6%	80.3%	2,893,656.26	3.7%	19.7%
Чанаргүй	6,639,362.20	3.1%	76.4%	2,050,644.20	2.6%	23.6%
<i>Хэвийн бус</i>	<i>1,782,537.24</i>	<i>26.8%</i>	<i>76.8%</i>	<i>537,097.39</i>	<i>26.2%</i>	<i>23.2%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>2,395,948.51</i>	<i>36.1%</i>	<i>85.0%</i>	<i>422,174.07</i>	<i>20.6%</i>	<i>15.0%</i>
<i>Муу</i>	<i>2,460,876.45</i>	<i>37.1%</i>	<i>69.3%</i>	<i>1,091,372.74</i>	<i>53.2%</i>	<i>30.7%</i>

Зээлийн ангиллын мэдээллийг хот, орон нутгаар ангилан харвал нийт зээлийн 72.9 хувь буюу 212,003,181.20 мянган төгрөгийг Улаанбаатар хотын ХЗХ-д, 27.1 хувь буюу 78,873,333.90 мянган төгрөгийг орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 91.3 хувь буюу 193,538,419.67 мянган төгрөгийг хэвийн, 5.6 хувь буюу 11,825,399.33 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 3.1 хувь буюу 6,639,362.20 мянган төгрөгийг чанаргүй

зээлийн үлдэгдэл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 37.1 хувь буюу 2,460,876.45 мянган төгрөгийг муу зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бөгөөд зах зээлийн нийт муу зээлийн 69.3 хувийг эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 93.7 хувь буюу 73,929,033.44 мянган төгрөгийг хэвийн, 3.7 хувь буюу 2,893,656.26 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 2.6 хувь буюу 2,050,644.20 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

ХЗХ-дын зээлийн багц 2021 оны 4 дүгээр улирлаас тайлант улирал хүртэл дунджаар 12.3 хувиар өссөн үзүүлэлттэй байгааг график 8-д харуулав.

График 8: Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)



Хүснэгт 16: Зээлийн бүтээгдэхүүнээр (мянган төгрөгөөр)

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Тайлант хугацаанд хаагдсан зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	10,085,280.41	7,750,428.34	4,866,489.79	1,599,741.22	11,369,477.74	3.9%
2	Уул уурхай, олборлолт	2,034,023.52	2,806,798.91	2,452,672.70	77,974.62	2,310,175.11	0.8%
3	Боловсруулах үйлдвэрлэл	7,871,880.85	9,553,110.88	5,634,156.12	3,128,665.95	8,662,169.66	3.0%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	310,011.34	69,000.00	39,412.15	25,333.95	314,265.24	0.1%
5	Усан хангамж; Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	179,741.44	140,000.00	90,043.11	69,546.79	160,151.53	0.1%
6	Барилга	4,681,941.49	7,941,759.04	5,372,458.52	2,644,517.03	4,606,724.98	1.6%
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	23,659,833.85	35,403,725.06	18,804,003.35	11,626,471.61	28,633,083.95	9.8%
8	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	5,257,527.52	5,329,316.58	4,015,586.14	1,632,532.48	4,938,725.48	1.7%
9	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1,933,998.66	3,294,375.50	2,643,695.32	399,877.09	2,184,801.75	0.8%
10	Мэдээлэл, холбоо	10,234.93	0.00	334.83	7,410.45	2,489.65	0.0%
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	52,752,753.08	32,111,673.65	12,504,941.57	7,804,225.34	64,555,259.82	22.2%
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3,611,094.49	6,287,161.10	5,768,979.64	370,472.22	3,758,803.74	1.3%

13	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	279,496.33	532,320.00	144,582.88	220,888.66	446,344.79	0.2%
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	83,753.43	420,300.00	185,551.44	96,662.17	221,839.81	0.1%
15	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	64,606.72	34,600.00	72,098.97	4,462.85	22,644.91	0.0%
16	Боловсрол	978,392.25	2,320,237.67	1,243,764.49	582,248.07	1,472,617.35	0.5%
17	Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	918,294.99	1,415,385.49	889,966.28	442,970.34	1,000,743.87	0.3%
18	Урлаг, үзвэр, тоглоом наадам	45,873.79	33,100.00	1,017.59	55,242.33	22,713.87	0.0%
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10,421,888.38	17,775,380.70	9,482,557.29	5,611,620.72	13,103,091.07	4.5%
20	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	36,474,890.27	15,659,808.83	429,558.06	8,048,522.53	43,656,618.50	15.0%
21	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.0%
22	Бусад (иргэн)	91,541,815.70	131,053,149.52	46,946,427.91	76,214,765.05	99,433,772.26	34.2%
23	Ногоон зээл	241,881.10	46,690.00	83,019.71	24,062.00	181,489.39	0.06%
<b>НИЙТ</b>		<b>253,197,333.45</b>	<b>279,931,631.25</b>	<b>121,588,298.13</b>	<b>120,664,151.46</b>	<b>290,876,515.11</b>	<b>100%</b>


2025 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д нийт 279,931,631.25 мянган төгрөгийн зээл олгож, 121,588,298.13 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлттэй, 120,664,151.46 мянган төгрөгийн зээл хаагдаж, 290,876,515.11 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг зээлийн бүтээгдэхүүнээр ангилахад нийт зээлийн үлдэгдлийн 34.2 хувь буюу 99,433,772.26 мянган төгрөгийг иргэнд олгосон бусад, 22.2 хувь буюу 64,555,259.82 мянган төгрөгийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 15.0 хувь буюу 43,656,618.50 мянган төгрөгийг хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, 9.8 хувь буюу 28,633,083.95 мянган төгрөгийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, 4.5 хувь буюу 13,103,091.07 мянган төгрөгийг үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 3.9 хувь буюу 11,369,477.74 мянган төгрөгийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын зориулалтаар тус тус авсан байна.

2024 оны 2 дугаар улирлаас ногоон зээлийн судалгааны тайланг авч эхэлсэн. Тайлант

улиралд 6 ХЗХ нийт 46,690.00 мянган төгрөгийн ногоон зээл олгож, 181,489.39 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гэж тайлагнасан байна. Нийт зээлийн үлдэгдлийн 80.9 хувийг ногоон барилга эзэлж байна.

Зээлийн зориулалтыг хуулийн этгээдийн ангиллаар харвал дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 43.7 хувь буюу 42,210,254.22 мянган төгрөг, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 38.5 хувь буюу 37,255,574.56 мянган төгрөг, жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 17.8 хувь буюу 17,190,107.46 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

График 9: Хуулийн этгээдийн ангилал (эцсийн үлдэгдэл)



## ДӨРӨВ. ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар

Хүснэгт 17: ХЗХ-дын эх үүсвэрийн бүтэц (мянган төгрөгөөр)

ЭХ ҮҮСВЭР	2024 оны IV улирал		2025 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Санхүүгийн өр төлбөр</b>	<b>270,633,623.32</b>	<b>75.9%</b>	<b>282,359,824.63</b>	<b>74.5%</b>	<b>11,726,201.32</b>	<b>4.3%</b>
Хадгаламж	266,734,200.31	74.8%	279,208,579.54	73.7%	12,474,379.23	4.7%
Нийт хадгаламж	248,630,979.72	69.7%	261,173,403.21	68.9%	12,542,423.49	5.0%
Хугацаагүй	5,271,505.43	1.5%	5,717,000.42	1.5%	445,494.99	8.5%
Хугацаатай	243,359,474.29	68.2%	255,456,402.79	67.4%	12,096,928.50	5.0%
Хадгаламжид хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	18,103,220.59	5.1%	18,035,176.33	4.8%	-68,044.26	-0.4%
<b>Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр</b>	<b>2,953,387.57</b>	<b>0.8%</b>	<b>1,943,433.39</b>	<b>0.5%</b>	<b>-1,009,954.18</b>	<b>-34.2%</b>
<b>Бусад санхүүгийн өр төлбөр</b>	<b>946,035.43</b>	<b>0.3%</b>	<b>1,207,811.70</b>	<b>0.3%</b>	<b>261,776.26</b>	<b>27.7%</b>
Дансны өглөг	703,665.17	0.2%	859,259.76	0.2%	155,594.59	22.1%
Ногдох хувь хөрөнгийн өглөг	218,465.44	0.1%	316,739.90	0.1%	98,274.46	45.0%
Салбар хоорондын тооцоо	814.83	0.0%	19,984.04	0.0%	19,169.21	2,353.6%
Түрээсийн өглөг	20,607.00	0.0%	11,828.00	0.0%	-8,779.00	-42.6%
Даатгалын өглөг	2,483.00	0.0%	-	-	-2,483.00	-100.0%
<b>Санхүүгийн бус өр төлбөр</b>	<b>3,408,620.64</b>	<b>1.0%</b>	<b>4,457,882.98</b>	<b>1.2%</b>	<b>1,049,262.34</b>	<b>30.8%</b>
Татварын өглөг	2,031,518.72	0.6%	3,028,458.61	0.8%	996,939.90	49.1%
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	54,698.62	0.0%	55,255.40	0.0%	556.78	1.0%
Ажиллагсадтай холбоотой өглөг	155,459.28	0.0%	162,427.96	0.0%	6,968.68	4.5%
Гишүүн байгууллагын татварын өглөг	100.00	0.0%	1,344.55	0.0%	1,244.55	1,244.6%
Холбоотой талд өгөх өглөг	57,345.68	0.0%	649,848.59	0.2%	592,502.90	1,033.2%
<b>Бусад санхүүгийн бус өр төлбөр</b>	<b>793,139.46</b>	<b>0.2%</b>	<b>560,547.87</b>	<b>0.1%</b>	<b>-232,591.59</b>	<b>-29.3%</b>
<b>Нөөц, болзошгүй өр төлбөр</b>	<b>316,358.88</b>	<b>0.1%</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-316,358.88</b>	<b>-100.0%</b>
<b>Өөрийн хөрөнгө</b>	<b>82,737,838.75</b>	<b>23.2%</b>	<b>92,163,162.72</b>	<b>24.3%</b>	<b>9,425,323.97</b>	<b>11.4%</b>
<b>Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>28,856,350.15</b>	<b>8.1%</b>	<b>30,251,442.78</b>	<b>8.0%</b>	<b>1,395,092.62</b>	<b>4.8%</b>
<b>Өмчийн бусад хэсэг</b>	<b>440,486.82</b>	<b>0.1%</b>	<b>587,134.82</b>	<b>0.2%</b>	<b>146,648.00</b>	<b>33.3%</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	196,634.85	0.1%	183,864.30	0.0%	-12,770.54	-6.5%
Хандив, тусламж	211,259.38	0.1%	263,138.95	0.1%	51,879.57	24.6%
Бусад	32,592.60	0.0%	140,131.57	0.0%	107,538.98	329.9%
<b>Хоршоологчдын өмч</b>	<b>53,441,001.77</b>	<b>15.0%</b>	<b>61,324,585.12</b>	<b>16.2%</b>	<b>7,883,583.35</b>	<b>14.8%</b>
Нөөцийн сан	14,550,791.26	4.1%	17,034,277.92	4.5%	2,483,486.67	17.1%
Тогтворжилтын сан	3,263,536.56	0.9%	3,748,582.03	1.0%	485,045.47	14.9%
Хадгаламж, хамгаалалтын сан	3,334,191.84	0.9%	3,836,182.51	1.0%	501,990.66	15.1%
Нийгмийн хөгжлийн сан	1,261,527.48	0.4%	1,647,924.16	0.4%	386,396.69	30.6%
Бусад сангууд	2,865,300.20	0.8%	3,604,284.90	1.0%	738,984.70	25.8%
Хуримтлагдсан орлого (алдагдал)	28,165,654.44	7.9%	31,453,333.61	8.3%	3,287,679.16	11.7%
Тайлант үеийн цэвэр орлого, алдагдал	15,295,012.14	4.3%	17,486,717.62	4.6%	2,191,705.48	14.3%
Өмнөх үеийн хуримтлагдсан орлого, алдагдал	12,870,642.30	3.6%	13,966,615.99	3.7%	1,095,973.69	8.5%
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө</b>	<b>356,780,082.71</b>	<b>100.0%</b>	<b>378,980,870.34</b>	<b>100.0%</b>	<b>22,200,787.63</b>	<b>6.2%</b>

Эх үүсвэрийн 74.5 хувийг санхүүгийн өр төлбөр, 1.2 хувийг санхүүгийн бус өр төлбөр, 24.3 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байгаа бол хадгаламж нийт эх үүсвэрийн 73.7 хувийг, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 0.5 хувийг, гишүүдийн оруулсан хувь хөрөнгө 8.0 хувийг, хоршоологчдын өмч 16.2 хувийг тус тус эзэлж байна. Хадгаламжийн хэмжээ

өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувиар өссөн ба хадгаламжид хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг хадгаламжийн үндсэн дансны 6.5 хувийг эзэлж байна.

## 4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар


Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 261,173,403.21 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 68.9 хувийг эзэлж байна. Нийт хадгаламжийн 97.8 хувийг хугацаатай хадгаламж, 2.2 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна. Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сарын

1.43 хувь, тайлант улиралд татан төвлөрүүлсэн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 1.47 хувь байгаа бол Улаанбаатар хотын ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 1.35 хувь, орон нутгийн ХЗХ-дын хувьд 1.63 хувь байна.

Хүснэгт 18: ХЗХ-дын хадгаламж, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Хадгаламжийн хэмжээ	ХЗХ-д	Хадгаламжийн дүн	Эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	4	142,492,008.70	54.6%
2	1,000,000.0-10,000,000.0	28	89,540,787.38	34.3%
3	500,000.0-1,000,000.0	19	13,260,089.16	5.1%
4	100,000.0-500,000.0	56	13,205,751.02	5.1%
5	50,000.0-100,000.0	20	1,454,313.61	0.6%
6	10,000.0-50,000.0	37	1,158,772.79	0.4%
7	5,000.0-10,000.0	7	54,607.35	0.0%
8	5,000.0 хүртэл	3	7,073.20	0.0%
9	Хадгаламжгүй	2	-	-
<b>Нийт дүн</b>		<b>176</b>	<b>261,173,403.21</b>	<b>100.0%</b>

График 10: ХЗХ-ны зах зээлийн хадгаламжийн өөрчлөлт (тэрбум төгрөгөөр)



Зах зээлийн нийт хадгаламжийн хэмжээ сүүлийн 5 жилд дунджаар 7.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## 4.3 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн талаар

Хүснэгт 19: ХЗХ-дын банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн бүтэц (мянган төгрөгөөр)

БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР	2024.IV улирал		2025.IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл</b>	<b>1,455,556.10</b>	<b>49.3%</b>	<b>642,737.98</b>	<b>33.1%</b>	<b>-812,818.13</b>	<b>-55.8%</b>
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	1,455,556.10	49.3%	632,737.98	32.6%	-822,818.13	-56.5%
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	-	-	10,000.00	0.5%	10,000.00	-
<b>Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хойшлогдсон төлбөр</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг</b>	<b>19,773.65</b>	<b>0.7%</b>	<b>18.81</b>	<b>0.0%</b>	<b>-19,754.83</b>	<b>-99.9%</b>
<b>Бусад (Төсөл, хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл)</b>	<b>1,478,057.82</b>	<b>50.0%</b>	<b>1,300,676.60</b>	<b>66.9%</b>	<b>-177,381.22</b>	<b>-12.0%</b>
<b>Нийт дүн</b>	<b>2,953,387.57</b>	<b>100.0%</b>	<b>1,943,433.39</b>	<b>100.0%</b>	<b>-1,009,954.18</b>	<b>-34.2%</b>

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 9 ХЗХ дотоодын банк болон санхүүгийн байгууллагаас 1,943,433.39 мянган төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашигласан байна. Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн 33.1 хувийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, 66.9 хувийг төсөл, хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

#### 4.4 Санхүүгийн бус өр төлбөрийн талаар

Хүснэгт 20: ХЗХ-дын санхүүгийн бус өр төлбөрийн бүтэц (мянган төгрөгөөр)

САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР	2024.IV улирал		2025.IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Татварын өглөг	2,031,518.72	59.6%	3,028,458.61	67.9%	996,939.90	49.1%
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	54,698.62	1.6%	55,255.40	1.2%	556.78	1.0%
Ажиллагсадтай холбоотой өглөг	155,459.28	4.6%	162,427.96	3.6%	6,968.68	4.5%
Гишүүн байгууллагын татварын өглөг	100.00	0.0%	1,344.55	0.0%	1,244.55	1,244.6%
Холбоотой талд өгөх өглөг	57,345.68	1.7%	649,848.59	14.6%	592,502.90	1,033.2%
<b>Бусад санхүүгийн өр төлбөр</b>	<b>793,139.46</b>	<b>23.3%</b>	<b>560,547.87</b>	<b>12.6%</b>	<b>-232,591.59</b>	<b>-29.3%</b>
Хойшлогдсон орлого	285,151.36	8.4%	241,885.14	5.4%	-43,266.22	-15.2%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд хамаарах өр	-	-	-	-	-	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	52,386.65	1.5%	31,190.40	0.7%	-21,196.24	-40.5%
Бусад	455,601.46	13.4%	287,472.33	6.4%	-168,129.13	-36.9%
<b>Нөөц, болзошгүй өр төлбөр</b>	<b>316,358.88</b>	<b>9.3%</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-316,358.88</b>	<b>-100.0%</b>
Хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлд байгуулсан нөөц	-	-	-	-	-	-
Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүргийн нөөц	316,358.88	9.3%	-	-	-316,358.88	-100.0%
Бусад нөөц	-	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>3,408,620.64</b>	<b>100.0%</b>	<b>4,457,882.98</b>	<b>100.0%</b>	<b>1,049,262.34</b>	<b>30.8%</b>

Санхүүгийн бус өр төлбөрийн 67.9 хувийг татварын өглөг, 12.6 хувийг бусад санхүүгийн өр төлбөр, 1.2 хувийг эрүүл мэнд, НДШ-ийн өглөг, 14.6 хувийг холбоотой талд өгөх өглөг, 3.6 хувийг ажиллагсадтай холбоотой өглөг тус тус эзэлж байна.

#### 4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ 30,251,442.78 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 8.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 21: ХЗХ-дын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо		Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн		Нэг гишүүн д ногдох хувь хөрөнгө Дүн
			Дүн	Хувь	Дүн	Хувь	
1	1,000,000.0 дээш	5	20,047	26.0%	14,701,329.77	48.6%	733.34
2	500,000.0-1,000,000.0	5	2,764	3.6%	3,330,481.05	11.0%	1,204.95
3	100,000.0-500,000.0	35	27,514	35.7%	7,383,973.53	24.4%	268.37
4	50,000.0-100,000.0	39	14,225	18.4%	2,819,242.50	9.3%	198.19
5	10,000.0-50,000.0	72	11,239	14.6%	1,878,847.12	6.2%	167.17
6	5,000.0-10,000.0	15	1,164	1.5%	123,560.02	0.4%	106.15
7	5,000.0 хүртэл	5	202	0.3%	14,008.79	0.0%	69.35
<b>Нийт дүн</b>		<b>176</b>	<b>77,155</b>	<b>100%</b>	<b>30,251,442.78</b>	<b>100%</b>	<b>392.09</b>

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө 100.0 сая төгрөгөөс дээш 45 ХЗХ

↓

ХЗХ-ны зах зээлийн гишүүдийн оруулсан нийт хувь хөрөнгийн 84.0%

↓

Нийт гишүүдийн 65.2%

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн 500 сая төгрөгөөс дээш үлдэгдэлтэй 10 ХЗХ-ны дүн зах зээлийн нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн 59.6 хувийг бүрдүүлж байна.

#### 4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 92,163,162.72 мянган төгрөгт хүрч, нийт эх үүсвэрийн 24.3 хувийг эзэлж байна. 500 саяас дээш өөрийн хөрөнгөтэй 30 ХЗХ-ны дүн зах зээлийн

өөрийн хөрөнгийн 81.5 хувийг бүрдүүлж байна. Тайлант улиралд 2 ХЗХ-ны нийт өр төлбөрийн хэмжээ нийт хөрөнгөөс хэтэрсэн буюу өөрийн хөрөнгөгүй болсон байна.

Хүснэгт 22: ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	18	66,462,069.24	72.1%
2	500,000.0-1,000,000.0	12	8,629,417.30	9.4%
3	100,000.0-500,000.0	64	13,465,486.05	14.6%
4	50,000.0-100,000.0	34	2,475,962.03	2.7%
5	10,000.0-50,000.0	41	1,145,779.04	1.2%
6	10,000.0 доош	5	33,500.76	0.0%
7	Өөрийн хөрөнгөгүй	2	-49,051.71	-0.1%
<b>Нийт дүн</b>		<b>176</b>	<b>92,163,162.72</b>	<b>100%</b>

Хүснэгт 23: ХЗХ-дын хоршоологчдын өмч, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Хоршоологчдын өмчийн дүн (интервалаар)	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	8	39,459,658.19	64.3%
2	500,000.0-1,000,000.0	13	9,398,477.40	15.3%
3	100,000.0-500,000.0	45	9,488,017.68	15.5%
4	50,000.0-100,000.0	24	1,620,767.52	2.6%
5	10,000.0-50,000.0	50	1,408,910.95	2.3%
6	5,000.0-10,000.0	16	113,947.62	0.2%
7	1,000.0-5,000.0	9	32,106.87	0.1%
8	1,000.0 хүртэл	4	1,871.31	0.0%
9	Хоршоологчдын өмчгүй	7	-199,172.43	-0.3%
<b>Нийт дүн</b>		<b>176</b>	<b>61,324,585.12</b>	<b>100.0%</b>

Тайлант улиралд нийт 7 ХЗХ хоршоологчдын өмчгүй болсон байна.

## ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

### 5.1 ХЗХ-дын орлогын талаар

Тайлант улиралд зах зээлийн нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.5 хувь буюу 12,087,420.89 мянган төгрөгөөр нэмэгдэж 89,938,726.73 мянган төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 96.4 хувь хүүгийн орлого, 1.6 хувь хүүгийн бус орлого, 2.0 хувь үйл ажиллагааны бус

орлого, олз эзэлж байна. Зээлийн хүүгийн орлого 79,740,243.91 мянган төгрөг нь нийт орлогын 88.7 хувийг бүрдүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.9 хувь буюу 14,314,945.00 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 24: ХЗХ-дын орлогын бүтэц (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2024.IV улирал		2025.IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>1. Хүүгийн орлого</b>	<b>74,112,330.30</b>	<b>95.2%</b>	<b>86,660,618.85</b>	<b>96.4%</b>	<b>12,548,288.55</b>	<b>16.9%</b>
Зээлийн хүүгийн орлого	65,425,298.91	84.0%	79,740,243.91	88.7%	14,314,945.00	21.9%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	1,475,945.74	1.9%	1,192,061.85	1.3%	-283,883.89	-19.2%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого (Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	7,470,661.21	9.6%	6,073,568.45	6.8%	-1,397,092.76	-18.7%
	259,575.55	0.3%	345,255.36	0.4%	85,679.81	33.0%
<b>2. Хүүгийн бус орлого</b>	<b>1,364,866.50</b>	<b>1.8%</b>	<b>1,421,744.31</b>	<b>1.6%</b>	<b>56,877.81</b>	<b>4.2%</b>
<b>3. Үйл ажиллагааны бус орлого, олз</b>	<b>2,374,109.03</b>	<b>3.0%</b>	<b>1,856,363.57</b>	<b>2.0%</b>	<b>-517,745.47</b>	<b>-21.8%</b>
<b>Нийт орлого</b>	<b>77,851,305.84</b>	<b>100.0%</b>	<b>89,938,726.73</b>	<b>100.0%</b>	<b>12,087,420.89</b>	<b>15.5%</b>

### 5.2 ХЗХ-дын зардлын талаар

Зах зээлийн нийт зардлын хэмжээ 72,452,009.11 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.8 хувь буюу 9,895,715.42 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт зардлын бүтцэд хүүгийн зардал 61.2 хувь, үйл ажиллагааны зардал 32.0 хувь, эрсдэлийн сангийн зардал 4.0 хувь, бусад зардал, гарз 0.2 хувийг тус

тус эзэлж байна. Хүүгийн зардал 44,347,378.61 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.8 хувь буюу 3,569,154.64 мянган төгрөгөөр өссөн байна. Зээлийн эрсдэлийн зардал өмнөх оны мөн үеэс 1 дахин буюу 1,515,790.77 мянган төгрөгөөр өсөж 2,928,224.78 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 25: ХЗХ-дын зардлын бүтэц (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2024.IV улирал		2025.IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Хувь	Дүн	Дүн	Хувь
<b>1. Хүүгийн зардал</b>	<b>40,778,223.96</b>	<b>65.2%</b>	<b>44,347,378.61</b>	<b>61.2%</b>	<b>3,569,154.64</b>	<b>8.8%</b>
Хадгаламжийн хүүгийн зардал	39,968,930.05	63.9%	43,791,305.14	60.4%	3,822,375.09	9.6%
Банкнаас авсан зээлийн хүүгийн зардал	553,296.35	0.9%	194,390.47	0.3%	-358,905.88	-64.9%
Санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	231,859.34	0.4%	523,470.36	0.7%	291,611.02	125.8%
Бусад хүүгийн зардал	51,307.78	0.1%	12,200.25	0.0%	-39,107.52	-76.2%
(Хүүгийн зардлын буцаалт)	27,169.55	0.0%	173,987.62	0.2%	146,818.08	540.4%
<b>2. Эрсдэлийн сангийн зардал</b>	<b>1,412,434.02</b>	<b>2.3%</b>	<b>2,928,224.78</b>	<b>4.0%</b>	<b>1,515,790.77</b>	<b>107.3%</b>
Зээлийн эрсдэлийн зардал	1,402,370.60	2.2%	2,911,224.78	4.0%	1,508,854.19	107.6%
Авлагын эрсдэлийн зардал	10,063.42	-	17,000.00	-	6,936.58	68.9%
Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн зардал	-	-	-	-	-	-
<b>3. Үйл ажиллагааны зардал</b>	<b>18,768,252.14</b>	<b>30.0%</b>	<b>23,215,345.11</b>	<b>32.0%</b>	<b>4,447,092.96</b>	<b>23.7%</b>
<b>4. Бусад зардал, гарз</b>	<b>122,827.95</b>	<b>0.2%</b>	<b>143,938.92</b>	<b>0.2%</b>	<b>21,110.96</b>	<b>17.2%</b>

Орлогын албан татварын зардал	1,474,555.62	2.4%	1,817,121.70	2.5%	342,566.08	23.2%
<b>Нийт зардал</b>	<b>62,556,293.70</b>	<b>100.0%</b>	<b>72,452,009.11</b>	<b>100.0%</b>	<b>9,895,715.42</b>	<b>15.8%</b>
<b>Цэвэр орлого</b>	<b>15,295,012.14</b>	<b>100.0%</b>	<b>17,486,717.62</b>	<b>100.0%</b>	<b>2,191,705.48</b>	<b>14.3%</b>


### 5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт орлого 89,938,726.73 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.5 хувь буюу 12,087,420.89 мянган төгрөгөөр нэмэгдэж, нийт зардал 72,452,009.11 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.8 хувь буюу 9,895,715.42 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр цэвэр орлого 17,486,717.62 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.3 хувь буюу 2,191,705.48 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 26: ХЗХ-дын ашигт ажиллагаа (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны IV улирал	2025 оны IV улирал
Нийт орлого	77,851,305.84	89,938,726.73
Нийт зардал	62,556,293.70	72,452,009.11
<b>Нийт орлогод зардлын эзлэх хувь</b>	<b>80.4%</b>	<b>80.6%</b>
Цэвэр орлого	15,295,012.14	17,486,717.62
<b>Нийт орлогод цэвэр орлогын эзлэх хувь</b>	<b>19.6%</b>	<b>19.4%</b>


График 13: ХЗХ-дын ашигт ажиллагаа (хувиар)



ХЗХ-ны зах зээлийн нийт орлого сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 11.3 хувиар, нийт зардал 10.7 хувиар, цэвэр орлого 14.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт орлогод эзлэх зардлын хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 пунктээр өсөж цэвэр орлогын эзлэх хувь буурсан байна.

График 14: ХЗХ-дын ашигт ажиллагаа (тэрбум төгрөгөөр)



## ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 27: ХЗХ-дын шалгуур үзүүлэлт хангасан байдал

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
<b>Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт</b>				
		325,075.54 мян.төг		
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	(30 ХЗХ) -6,841.15 мян.төг (7 ХЗХ)	37	21.0%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	24	13.6%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	16	9.1%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	3	1.7%
<b>Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт</b>				
5	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	36	20.5%
6	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	4	2.3%
7	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	40%-80%	50	28.4%
8	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	7	4.0%
9	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	3	1.7%
10	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	20	11.4%
11	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	31	17.6%
12	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	18	10.2%
13	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	19	10.8%
<b>Зардлын зохистой хэмжээ</b>				
14	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	82	46.6%
<b>Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар</b>				
15	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	10%-аас доошгүй	15	8.5%
<b>Өгөөж, зардлын хувь хэмжээ</b>				
16	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			4.6%

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ХЗХ-дын 17.0 хувь буюу 30 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 325,075.54 мянган төгрөгөөр илүү байгуулсан бол 4.0 хувь буюу 7 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 6,841.15 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байна. Нийт ХЗХ-дын 13.6 хувь буюу 24 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцаа, 20.5 хувь буюу 36 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 28.4 хувь буюу 50 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 17.6 хувь буюу 31 ХЗХ нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээг, 11.4 хувь буюу 20 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 46.6 хувь буюу 82 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, 8.5 хувь буюу 15 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. ХЗХ-ны зах зээлийн хөрөнгийн өгөөж 4.6 хувь байна.

Хүснэгт 28: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	ХЗХ-дын тоо	Хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	36	20.5%
2	1 ЗХШҮ хангаагүй	58	33.0%
3	2 ЗХШҮ хангаагүй	35	19.9%
4	3 ЗХШҮ хангаагүй	13	7.4%
5	4 ЗХШҮ хангаагүй	17	9.7%
6	5 ЗХШҮ хангаагүй	17	9.7%
<b>Нийт дүн</b>		<b>176</b>	<b>100.0%</b>

Тайлант улиралд ХЗХ-дын 20.5 хувь буюу 36 ХЗХ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан бол 9.7 хувь буюу 17 ХЗХ 5 болон түүнээс дээш зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй байна.